

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3 – 4

1. *Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/*

3 – 4

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 04 дүгээр сарын 14-ний өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Б.Бейсен, М.Ганхүлэг;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ц.Идэрбат, Д.Үүрийнтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баярмаа, М.Нарантуяа-Нара, Б.Түвшин.*

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Л.Энхнасан: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 07 минут үргэлжилж, 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
10 цаг 10 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа гишүүн, 10 дугаар тойрог Хөхөөгийн Болормаа гишүүн, 8 дугаар тойрог Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, 8 дугаар тойрог Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нар иржээ. 10 дугаар тойргийн Цэндийн Баатархүү гишүүн чөлөөтэй, 6 дугаар тойрог Цагаанхүүгийн Идэрбат гишүүн чөлөөтэй, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн чөлөөтэй байна. Мөн 4 дүгээр тойрог Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн орон нутагт томилолттой, Жадамбаагийн Баясгалан гишүүн орон нутагт томилолттой, 3 дугаар тойргийн Буланы Бейсен гишүүн орон нутагт томилолттой, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн орон нутагт томилолттой, Жудагийн Баярмаа өвчтэй, Мөнхтөрийн Нарантуяа гишүүн өвчтэй, Банзрагчийн Түвшин гишүүн өвчтэй байна. Хуралд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцууллаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн байхгүй байна. Байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё. /алх цохив/

2025 оны Байнгын хорооны 02 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүний нэр дэвшигчдийн сонсголын товыг тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголыг зайлшгүй хойшлуулах шаардлага үүссэн тул өнөөдөр

тус тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх гэж байна. Нэр дэвшигчийн сонголыг ирэх хоёр дахь өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр байхаар товлох саналтай байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан саналтай болон асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

А.Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу?

А.Ариунзаяа: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд томилогдож байгаа гишүүний сонголттой уялдуулан түүнээс өмнө Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсох хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгээд яг энэ сонсголоос өмнө бас зохион байгуулж, сонголд орохдоо яг эдгээр тулгамдаж байгаа асуудлуудыг тухайн хүнд сануулах, хэлэх хэрэгцээ шаардлага байгаа учраас өмнө нь энэ ажлыг зохион байгуулахыг хүсэж байна.

Л.Энхнасан: Ойлголоо. Энэ саналыг хүлээж авлаа.

Ер нь энэ долоо хоногтоо заавал хэвлэл мэдээллийг оролцуулахгүйгээр бид Эрүүл мэндийн даатгал болон эмнэлгийн төлөөллүүдийг тус тусад нь оролцуулсан хурал зохион байгуулъя.

Хэлэлцэх асуудалтай хүмүүс асуулт, үгээ хэллээ.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн нэр дэвшигчийн сонголын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр товлох санал хураалт явуулъя.
/алх цохив/

54.5 хувиар санал дэмжигдэж Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт орлоо.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Ингээд Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө.

Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 07 минут үргэлжилж, 10 цаг 17 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД